БАТЛАВ.

ХӨШИГИЙН ХӨНДИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН
АСУУДАЛ ХАРИУЦСАН ЗАХИРГААНЫ ДАРГА /М.БАТБАЯР/

УЛААНБААТАР ХОТ
ХӨШИГИЙН ХӨНДИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН ЗАХИРГАА ТЕАГ
6750354 УБТТ5335

# “ШИНЭ ЗУУНМОД ХОТЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТ МЭДЭЭЛЭЛ, СУРТАЛЧИЛГААНЫ ТӨВ”- Н БАРИЛГЫН АЖЛЫН ЗУРАГ, ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

2024 он 05 сар 28 өдөр Дугаар: *ХХББАХЗ/20240103014* Улаанбаатар хот

| | | |
|---|---|---|
| 1. | Зураг төсөл боловсруулах үндэслэл | - УИХ-ын 2020 оны “Алсын хараа-2050” “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай” 52 дугаар тогтоол;<br>- УИХ-ын 2020 оны “Монгол Улсыг 2021-2025 онд хэрэгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах” 23 дугаар тогтоол;<br>- УИХ-ын 2020 оны “Хот байгуулах тухай” 55 дугаар тогтоол;<br>- УИХ-ын 2024 оны “Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай” 12 дугаар тогтоол;<br>- ЗГ-ын 2021 оны “Тусгай хэрэгцээний газарт хамааруулах тухай” 307 дугаар тогтоол;<br>- ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр;<br>- ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө;<br>- ЗГ-ын 2022 оны “Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай” 143 дугаар тогтоол. |
| 2. | Зорилго, ач холбогдол | “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан эдийн засгийн тэргүүлэх бүс нутаг, салбаруудыг хөгжүүлэх, шинэ хот байгуулах болон дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, цар тахлын дараах санхүү, эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлыг богино хугацаанд сайжруулах, шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд “Шинэ Зуунмод” хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний бүрдэл Шинэ Зуунмод хотын бүтээн байгуулалтын менежмент мэдээлэл, сурталчилгааны төвийг байгальд ээлтэй, Шинэ Зуунмод хотын өнгө төрхийг илтгэх, орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмжөөр хангагдсан оффисын барилгыг барьж байгуулна. Ингэснээр Шинэ Зуунмод хотын бүтээн байгуулалт удирдлага, менежментийн байгууллагууд, олон улсын байгууллагууд, Шинэ Зуунмод хотод үйл ажиллагаа явуулах гэж буй хуулийн этгээд, иргэдэд зориулсан бүрэн тохижуулсан оффис мөн хөрөнгө оруулагч, бизнес түншүүдтэй холбоо тогтоох хурал, уулзалт, үзэсгэлэнгийн танхимууд бий болгосноор ажиллах таатай нөхцөл бүрдэнэ. |
| 3. | Барилга байгууламжийн байршил, газар олголтын тогтоол захирамж | - Төв аймгийн Сэргэлэн сум, Хөшигийн хөндий, Шинэ Зуунмод хотын засаг захиргааны бүсэд<br>- ЗГ-ын 2021 оны “Үндэсний хэмжээний бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зориулалтаар газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай” 307 дугаар тогтоол. |
| 4. | Зориулалт, хүчин чадал /бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрлөөр/ | - “Шинэ Зуунмод хотын бүтээн байгуулалтын менежмент мэдээлэл, сурталчилгааны төв”-н оффис, хурал үзэсгэлэнгийн зориулалттай.<br><br>Нийт 11000 м2- с багагүй талбайтай байна.<br>- Цаашид өргөтгөж цогцолбор байдлаар тооцож төлөвлөх<br>- Судалгааны ажлын явцад холбогдох норм, дүрмийн дагуу дахин нарийвчлан тооцож захиалагчтай зөвшилцөх. |

| | | |
|---|---|---|
| 5. | Барилгын давхрын тоо | - Газрын түвшнээс дээш 6 давхар /Иргэний нисэхийн багц дүрмүүд, энэ даалгаварын 7-р хэсгийг үзэх/;<br>- Газрын түвшнээс доош 1-ээс доошгүй давхар төлөвлөх. |
| 6. | Дагаж мөрдөх ерөнхий төлөвлөгөө, ерөнхий төлөвлөгөөний бүсчлэл | - Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 143 дугаар тогтоол /Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө/;<br>- Шинэ Зуунмод хотын төв, засаг захиргааны бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулах. |
| 6. | Талбайн ерөнхий төлөвлөгөө, тохижилтонд тавигдах шаардлага | - Төлөвлөж буй барилгын хүрээлэн буй орчин, гадна орон зайн тохижилтыг орчин үеийн хэв загвартай, тухайн нутаг дэвсгэрийн зохион байгуулалт, орон зайн зохиомж цаашид төлөвлөх барилга байгууламжийн хэв загварын чиг хандлага, архитектуртай нь уялдуулсан орчин үеийн барилгад тавигдах шаардлагыг хангасан төлөвлөлтийн шийдэлтэй байхаар төлөвлөх;<br>- Төлөвлөж буй барилгын гадна орон зайн тохижилтын зураг төслийг холбогдох норм, нормативын баримт бичиг, дүрэм, журамд заасны дагуу төлөвлөсөн байх;<br>- Ногоон байгууламж, архитектурын жижиг элементүүд болон уран баримал, хөшөө, ландшафтын тохижилт, усан оргилуур, гадна гэрэлтүүлгийн хамтаар өвөрмөц шийдэл бүхий тохижилттой байхаар төлөвлөх;<br>- Авто тээврийн хэрэгслийн болон унадаг дугуйн гадна зогсоол, явган хүний зам, гарц, талбайг холбогдох норм, дүрэм, стандартын дагуу төлөвлөж, гэнэтийн осол, онцгой байдлын нөхцөл үүссэн үед зам, талбайг ажиллагсдын цугларах, аюулгүй байдлаар ашиглах боломжийг хангасан байхаар төлөвлөх;<br>- Гадна талбайд 200-с доошгүй автомашины зогсоол төлөвлөх;<br>- Авто зам, тээврийн хэрэгслийн зогсоол, явган хүний гарцыг холбогдох стандартын дагуу төлөвлөх;<br>- Гэрэлтүүлэг, авто зогсоол, цэцэрлэгжүүлэлт, орц гарцыг тухайлсан норм ба дүрмийн шаардлагыг хангуулан цогц байдлаар төлөвлөх;<br>- Цахилгаан машины цэнэглэгч станцтай байх;<br>- Хог цуглуулах талбай руу орох орц, хүнс тээвэрлэн нэвтрэх орц, бие даасан хүрэх зам нь хатуу хучилттай, хог цуглуулах талбай нь хаалт бүхий тусгаарлагчтай байх;<br>- Ногоон байгууламжийн хэсэгт амралтын бүс төлөвлөх;<br>- Барилгын орчны байгууламж руу очих явган хүний замыг хатуу хучилттай байхаар төлөвлөх;<br>- Гол орц хэсэгт хүндэт зочид, айлчлал хүлээн авах боломжтойгоор төлөвлөх.<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан төлөвлөлтөд тавигдах шаардлага:<br>- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан авто зогсоол төлөвлөх;<br>- Явган хүний зам нь хатуу нягт, халтирахаас сэргийлсэн гадаргуугаар хийгдсэн байх бөгөөд хөтөч хавтан төлөвлөх;<br>- Налуу замыг стандартын дагуу 1:12 бариултай төлөвлөх;<br>- Онцгой нөхцөлд ашиглах орц, гарц төлөвлөх. |
| 7. | Архитектур төлөвлөлтийн шаардлага | - Барилгын ерөнхий шийдлийг тодорхойлж тайлбарласан байх<br>- Барилгын гадна ханын өнгөлгөө нь керамик хавтанцар, шилэн болон металл хосолсон холимог фасадтай байх;<br>- Байгууллагуудын оффисын хэсэгт газар, нэгжүүд шилэн ханаар тусгаарлах боломжтой байдлаар төлөвлөх;<br>- Аль нэг давхарт зохион байгуулагдах үзэсгэлэн, макет, зураг төсөлтэй холбоотой үзүүлэн байршуулах талбай төлөвлөх; |

| | | |
|---|---|---|
| | | - Шинэ Зуунмод хотод төсөл хэрэгжүүлэх байгууллагуудын ажилчдыг байршуулах зориулалттай өрөө төлөвлөх;<br>- Барилгад хэрэглэх материалын технологийн шаардлагыг тодорхойлж тайлбарласан байх;<br>- Барилгын хүрээлэн буй орчинтой уялдуулж явган зам, дугуйн зам, авто замын тасралтгүй үргэлжлэх системийг хангаж төлөвлөх;<br>- Байгаль орчинд ээлтэй төлөвлөлтийн шийдлийг тусгасан байх<br>- Салхилах, тамхилах тагт бүхий шийдэлтэй байх /тухайлсан давхарт/;<br>- Аврах гарц болон гадагш гарах гарцуудаас хамгийн алслагдсан өрөө, тасалгааны хаалганаас ойр орших хонгил гарц хүртэлх аврах замын уртыг холбогдох норм дүрмийн дагуу төлөвлөх;<br>- Барилгын аль нэг хананд тухайн хотын агуулга илэрхийлсэн монументал ханын чимэглэлтэй байх;<br>- Барилгын дээврийг ашиглалттай байхаар төлөвлөх;<br>Захиргааны зориулалттай олон нийтийн барилга төлөвлөх нормыг бүрэн хангасан байх;<br>Захиргааны газрын барилга /дотор инженерийн шугам сүлжээний бүх хангамжаар тоноглогдсон/, гадна тохижилт, зам талбайн хамт.<br>**Нэг, Хоёрдугаар давхарт:**<br>- Угтах хэсэг<br>- Хувцасны өлгүүр<br>- Үүдний танхим, лобби /макет байрлуулах талбай бүхий/<br>- Олон нийт, хэвлэл мэдээллийн төв<br>- Сувилахуйн өрөө<br>- Нэг цэгийн үйлчилгээний танхим<br>- Банк<br>- Бичиг хэргийн өрөө<br>- Зоогийн газар, гал тогоо /тохиромжтой газар төлөвлөх/<br>- Кофе шоп<br>- Серверийн өрөө<br>- Үзэсгэлэнгийн танхим<br>- Уулзалтын өрөө<br>- Хурлын танхим, зөвлөлийн өрөө<br>- Ногоон байгууламж /дотор цэцэрлэгт хүрээлэн/<br>- Харуул, CCTV хяналтын өрөө<br>- Задгай орон зай төлөвлөх<br>**Хотын захирагч, ажлын алба;**<br>**Ерөнхий архитектор, ажлын алба;**<br>**Чөлөөт бүсийн ажлын алба;**<br>**Шинэ Зуунмод хотын хөгжлийн корпораци;**<br>**Нийтийн үйлчилгээний хэсэгт:**<br>- Хуралдааны танхим<br>- Хурлын өрөө<br>- Хяналт, удирдлагын өрөө<br>- Номын сан<br>- Архив<br>- Олон үйлдэлтэй хурлын танхим / суудлын тоо 450/<br>- Чийрэгжүүлэх танхим<br>**Оффисын хэсэгт:**<br>- Оффисын өрөөнүүд<br>- Нэг цэгийн үйлчилгээний оффис<br>- Уулзалтын өрөө<br>- Цайны өрөө<br>- Амралтын өрөө |

| | | |
|---|---|---|
| | | **Зоорийн давхарт:**<br>- Техникийн өрөө<br>- Туслах хэрэгслийн хадгалах агуулахууд<br>- Авто машины зогсоол /хүчин чадлаар/<br>**Давхар бүрд /зоорийн давхраас бусад/:**<br>- Ариун цэврийн өрөө<br>- Үйлчлэгчийн өрөө<br>- Шаардлагатай өрөө тасалгааг зураг төслийн шатанд захиалагчтай зөвшилцөх |
| 8. | Инженерийн шугам сүлжээ, түүнийг хангах эх үүсвэр /дулаан, усан хангамж ариутгах татуурга, цахилгаан холбоо, инженерийн хангамж/ | **Улсын төсвийн хөрөнгө оруулалт:** Төвлөрсөн болон бие даасан эх үүсвэрээр:<br>- Дулаан хангамж<br>- Ус хангамж<br>- Ариутгах татуурга<br>- Цахилгаан хангамж<br>- Холбоо дохиолол<br>**Хатуу хог хаягдал:**<br>- Хог хаягдлыг ангилан цуглуулах талбай, ялган хадгалах цэг<br>- Бохир хог хаягдлыг ангилан цуглуулж устгах талбай |
| 9. | Инженер- геологийн судалгааны талаарх шаардлага | Тухайн ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдээр гүйцэтгүүлнэ. |
| 10. | Газар хөдлөлтийн баллын шаардлага | Инженер геологийн судалгааны дүгнэлтээр тодорхойлогдоно. |
| 11. | Галын аюулгүй байдлын нөхцөл | Галын аюулаас урьдчилан сэргийлэх, галын аюулаас хамгаалах, нөхцөлийг төлөвлөлтөд тусгах, "Барилга байгууламжийн галын аюулгүй байдал" БНбД 21-01-02, "Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм" БНбД 21-02-02, "Барилга байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж дохиоллын хэрэгслэл" БНбД 21-04-05*/18-ыг шаардлагыг хангасан байна |
| 12. | Гал тэсвэршилтийн зэрэг | - II-р зэрэг |
| 13. | Зураг төслийн бүрдэл | Баримт бичгийн бүрдэл:<br>- Газар олголтын схем, захирамж;<br>- Архитектур төлөвлөлтийн даалгавар – ШЗМ хотын эрхзүйн байдлын тухай хуулийн зохицуулалтыг дагаж хийгдэнэ;<br>- Техникийн нөхцөл;<br>- Загвар зураг;<br>- Инженер геологийн дүгнэлт;<br>- Урьдчилсан ТЭЗҮ Батлагдсан загвар зурагт үндэслэн боловсруулах.<br>Барилга байгууламжийн ажлын зураг төсөл:<br>- Ерөнхий төлөвлөгөө<br>- Гадна тохижилт<br>- Гадна гэрэлтүүлэг<br>- Барилга архитектур<br>- Барилга бүтээц<br>- Дотор халаалт, агаар сэлгэлт<br>- Цэвэр, бохир ус<br>- Хүчит төхөөрөмж, дотор гэрэлтүүлэг<br>- Холбоо дохиолол, автоматик<br>*Зураг төслийг боловсруулах тооцоо, судалгаа хийх үед зураг төслийн иж бүрдэл нэмэгдэх боломжтой.*<br>Ажил гүйцэтгэх аргачлал:<br>Баталгаажуулсан загвар зураг /эх хувь-1, хуулбар хувь-1/ |

| | | |
|---|---|---|
| | | - Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах магадлал хийх дүрэм"-ийн дагуу боловсруулж, иж бүрэн ажлын зураг, анимейшн, төсвийг холбогдох баримт бичгүүдийн хамт эх хувь 1, хуулбар 3 хувь хэвлэмлээр, файл хэлбэрээр CD бичиж 1 хувь хүлээлгэн өгнө. |
| 11. | Зураг төсөл боловсруулах ажлын үе шат | **Загвар зургийн үе шат:**<br>- Загвар зураг /Батлагдсан архитектур төлөвлөлтийн даалгаварт үндэслэсэн байх/<br>- Урьдчилсан ТЭЗҮ /Батлагдсан загвар зургийн дагуу/<br>**Зураг төслийн үе шат:**<br>- Ажлын зураг төсөл<br>- Төсөв<br>- Магадлал хийлгэж нэгдсэн дүгнэлт гаргах |
| 12. | Ашиглах материал | **Монгол улсын хуулиуд:**<br>- Монгол Улсын Үндсэн хууль<br>- Хот,тосгоны эрх зүйн байдлын тухай хууль<br>- Хот байгуулалтын тухай хууль<br>- Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль<br>- Барилгын тухай хууль<br>- Газрын тухай хууль<br>- Авто замын тухай хууль<br>- Галын аюулгүй байдлын тухай хууль<br>- Аж ахуй нэгж үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль<br>- Архивын тухай хууль<br>- Эрчим хүчний тухай хууль<br>- Байгаль орчны тухай хууль<br>- Харилцаа холбооны тухай хууль<br>**Норм, нормативууд:**<br>- Барилга байгууламжийн галын аюулгүй байдлын техникийн зохицуулалт 2023 он;<br>- Барилга байгууламжийн аюулгүй байдлын техникийн зохицуулалт 2023 он;<br>- Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНбД 30-01-04/<br>- Олон нийт иргэний барилга /БНбД 31-03-03*/11/<br>- Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт /БНбД 23-01-09/<br>- Барилга байгууламжийн галын аюулгүй байдал /БНбД 21-01-02/<br>- Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм /БНбД 21-02-02/<br>- Авто зогсоол /БНбД 21-02-02/<br>- Барилга байгууламжийн буурь, суурийн зураг төсөл зохиох /БНбД 50-01-16/<br>- Ачаа ба үйлчлэл /БНбД 20-04-17/<br>- Барилгын орчны тохижилтын ажлын норм ба дүрэм /БНбД 3.01.06-90/<br>- Ус хангамж. Гадна сүлжээ ба байгууламж /БНбД 40-02-16/<br>- Гадна дулаан хангамж /БНбД 81-23-06/<br>- Халаалт, агаар сэлгэлт ба кондиционер /БНбД 41-01-11/<br>- Тоног төхөөрөмж ба дамжуулах хоолойн дулаан тусгаарлалт /БНбД 41-04-13/<br>- Барилга байгууламжийн гал унтраах төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл /БНбД 21-04-05*/18/<br>- Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх норм ба дүрэм |

| | | |
|---|---|---|
| | | /БД 22-101-07/<br>- Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг /БНбД 23-02-08/<br>- Барилгын дулаан хамгаалалт /БНбД 25-01-20/<br>- Ариутгах татуурга. Гадна сүлжээ ба байгууламж /БНбД 40-01-14/<br>- Барилга доторхи усан хангамж, ариутгах татуурга /БНбД 40-05-16*/20/<br>- Халаалт агаар сэлгэлт ба кондиционер /БНбД 41-01-11/<br>- Дулааны сүлжээ /БНбД 41-02-13/<br>- Дулаан хуваарилах төв /БД 41-103-11/<br>- Цутгамал бетон, төмөр бетон бүтээц /БНбД 52-02-05/<br>- Автоматжуулалтын систем /БНбД 3.05.07-90/<br>- Цахилгаан техникийн ажил /БНбД 3.05.06-90/<br>- Барилгын төсөв зохиох дүрэм /БНбД 81-95-12*/20/<br>- Барилга, байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийг төлөвлөх / БНбД 35-01-22/<br>- Барилга байгууламжийн инженер- экологийн судалгаа /БД 11-102-07/<br>- Барилгын дулаан хамгаалалтын төлөвлөлт /БД 23-103-10/<br>- Халаалтын системийн металл, полимер хоолой төлөвлөх ба угсрах /БД 41-101-08/<br>- Орон сууц, олон нийтийн барилгын цахилгаан тоног төхөөрөмжийг төлөвлөх ба угсрах барилгын дүрэм /БД 43-102-07/<br>- Барилга байгууламжийн аянга хамгаалалтын зураг төсөл зохиох заавар /БД 43-103-0/<br>- Цахилгаан байгууламжийн дүрэм. Бүлэг 1,6 газардуулга ба цахилгааны аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ /БД 43-101-03*12/<br>- Цахилгаан байгууламжийн дүрэм /БД 43-101-03/<br>- Иргэний нисэхийн багц дүрмүүд<br>- Олон улсын Иргэний нисэхийн байгууллага (ICAO)-аас тавигддаг шаардлага<br>**Дүрэм журам, стандартууд:**<br>- Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм<br>- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөтөч зам, налуу шатыг шийдэх /MNS 6056:2003, 6055:2009/<br>- Явган хүн болон хөгжлийн бэршээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар /MNS 6056:2009/<br>- Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцон орон зай, орчин /MNS 6056:2009/<br>- Цахилгаан тоног төхөөрөмж, гүйдэл дамжуулагчийн таних тэмдэглэгээ. Ерөнхий шаардлага /MNS 3757-16:2015/<br>- Бүдүүвч дэх автоматжуулалтын хэрэгсэл ба багажийн таних тэмдэглэгээ /MNS 4187-93/<br>- Олон улсын цахилгаан техникийн хорооны таних тэмдэглэгээ /MNS IEC 60617/<br>- Барилгын зураг төслийн баримт бичгийн систем, холбоо ба дохиоллын ажлын зураг /MNS 6586:2016/<br>- Холбоо мэдээлэл дохиололын кабель шугам ба тоног төхөөрөмжийн тэмдэглэгээ /MNS 5532:2016/<br>- Барилгын дотор холбоо дохиоллын сувагчлал ба кабелийн угсралт хийх /MNS 5471:2005/<br>- Барилгын эталон зураг хэрэглэх заавар<br>- |

| | | |
|---|---|---|
| | | **Бусад холбогдох норм, дүрэм**<br>- Дээрх хууль болон норм, нормативын баримт бичгүүдэд зааснаас бусад болон онцгой шаардлагатай тохиолдолд олон улсын норм, дүрмийг баримтална. |
| 15. | Эдийн засгийн тооцоо, төсөв, ТЭЗҮ | Урьдчилсан Техник эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-г батлагдсан загвар зурагт тулгуурлан боловсруулна. Захиалагч байгууллагаар батлуулах |
| 17. | Онцгой нөхцөл | - Орчин үеийн шийдэлтэй, архитектур төлөвлөлтийн шинэлэг дүр төрхтэй байх;<br>- Ажилчдын хөдөлмөрийн эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангасан байх;<br>- Ухаалаг автоматжуулалтын системээр тоноглогдсон байх;<br>- Дэвшилтэт техник, технологи, цахилгаан, дулаан, уур, усны эх үүсвэрийг ашигтай төлөвлөх; /Эрчим хүчний хэмнэлттэй/<br>- Галын мэдээллийн систем, хий, утаа болон үерийн дохиоллын систем, автоматжуулалтын систем, инженерийн тоног төхөөрөмжийн систем, мөн нэгдсэн холбоо дохиоллын систем зэргийг тусгасан байх;<br>- Барилгыг төлөвлөх, барьж байгуулах болон тоноглохдоо тухайн барилгад ажиллагсад, ирэх зочид барилгын дотор болон ойр орчимд орж, гарахдаа явганаар юм уу хөдөлгөөнт хэрэгсэл ашиглах үед мөн инженерийн тоног төхөөрөмжтэй харьцах үед учирч болох осол, гэмтлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тусгах;<br>- Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө нэмэгдэж байгаатай холбогдуулан сэргээгдэх эрчим хүчээр хангах боломжийг тусгах;<br>- “Барилгын дулаан хамгаалалт” БНбД 25-01-20 Барилгын норм дүрэмд заасан орон сууц, олон нийтийн барилгын эрчим хүч хэмнэлтийн В ангиллыг хангасан байх;<br>- Орчин үеийн шаардлагад нийцсэн цахим системээр тоноглогдсон байх;<br>- Иргэдэд нээлттэй мэдээлэх зориулалт бүхий фасадын лед дэлгэцтэй байх;<br>- Нөхөн сэргээлтийн ажлын зардлыг тооцож төсөвт тусгах;<br>- Тус барилга байгууламж нь хөдөлгөөний хязгаарлалттай, сонсгол, харааны хязгаарлалттай, өндөр настай хүний хэрэгцээ шаардлагыг бүрэн хангасан байх; |
| 18. | Боловсруулах хугацаа | Захиалагч болон сонгон шалгаруулалтаар шалгарсан зураг төсөл гүйцэтгэгч хуанлийн 90 хоног |
| 19. | Хөрөнгө оруулалт | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар |
| 20. | Захиалагч байгууллага | Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа |
| 21. | Зураг төслийн байгууллага | Холбогдох заалтыг хангасан тусгай зөвшөөрөл бүхий тендерт шалгарсан байгууллага байна. |
| 22. | Эдийн засгийн тооцоо төсөв | Төсвийг ESTIMATOR-PRO программ болон эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн программаар тооцно. |
| 23. | Зөвшилцөх байгууллага | - Хөшигийн Хөндийн Бүтээн Байгуулалтын Асуудал Хариуцсан Захиргаа;<br>- Онцгой байдлын газар;<br>- Эрүүл мэндийн яам;<br>- Барилгын Хөгжлийн Төв;<br>- Бусад /Шинэ Зуунмод хотын эрхзүйн байдлын тухай хуулиар зохицуулах/;<br>- Аэродром төлөвлөлтийн шаардлагын дагуу зохих байгууллагатай зөвшилцөх. |

**Хянасан:**

ХӨШИГИЙН ХӨНДИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР — Б. ГҮНБОЛД

ХӨШИГИЙН ХӨНДИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН ЗАХИРГААНЫ ЗАХИРГАА, САНХҮҮ, ХҮНИЙ НӨӨЦИЙН ГАЗРЫН ДАРГА — С.БАТЦЭЦЭГ

ХӨШИГИЙН ХӨНДИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН ЗАХИРГААНЫ БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН ГАЗРЫН ДАРГА — Д.ЖАРГАЛ

**Боловсруулсан:**

ХӨШИГИЙН ХӨНДИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН ЗАХИРГААНЫ ЗУРАГ ТӨСЛИЙН АХЛАХ АРХИТЕКТОР — Ө.ЦЭРЭНБАЗАР

ХӨШИГИЙН ХӨНДИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН ЗАХИРГААНЫ БАРИЛГЫН АХЛАХ ИНЖЕНЕР — Д.НАНДИНЦЭЦЭГ

ХӨШИГИЙН ХӨНДИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН ЗАХИРГААНЫ ХӨГЖЛИЙН САНХҮҮГИЙН ШИНЖЭЭЧ — И.ГЭРЭЛМАА

2024 оны 05 дугаар сарын 28-ны өдөр